

“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 03 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолд тус тус заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2021 оны гүйцэтгэлийн тайланг, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хурлын Тамгын газарт 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” /цаашид “үйл ажиллагааны хөтөлбөр” гэх/ болон Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-нд тулгуурлан хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэлээ.

НЭГ. “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” нь 6 бодлогын хүрээнд 234 зорилт, 1031 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан 1031 арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх хугацаагаар нь авч үзвэл:

- 2017-2019 онд хэрэгжүүлж, 2020 оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй 4 арга хэмжээ буюу 0.4 хувь;
- 2020 оноос хэрэгжүүлэх 442 арга хэмжээ буюу 42.9 хувь;
- 2021 оноос хэрэгжүүлэх 482 арга хэмжээ буюу 46.8 хувь;
- 2022 оноос хэрэгжүүлэх 78 арга хэмжээ буюу 7.6 хувь;
- 2023 оноос хэрэгжүүлэх 20 арга хэмжээ буюу 1.9 хувь;
- 2024 оноос хэрэгжүүлэх 4 арга хэмжээ буюу 0.4 хувь;
- Хэрэгжиж эхлэх хугацаа тавиагүй 1 арга хэмжээ байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан нийт арга хэмжээг үнэлэхдээ тухайн жилийнхээ шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг хянан үзэж төсөл, арга хэмжээ тус бүрээр үнэллээ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 6 бодлогын хүрээнд дэвшүүлсэн нийт **234** зорилт, 1031 арга хэмжээнээс **701** арга хэмжээний хэрэгжилтийн тайланг ирүүлсэн. Засгийн газраас хөтөлбөрийн хэрэгжилтийг **74.5** хувийн

хэрэгжилттэй гэж үнэлсэн бөгөөд харин Улсын Их Хурлын Тамгын газраас 2021 оны жилийн эцсийн байдлаар **69.6** хувьтай гэж үнэллээ. Үүнд:

Хүснэгт 1.Хөтөлбөрт тусгагдсан бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн байдал

№	Бодлогууд	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн дундаж хувь	
					/Засгийн газар/	/УИХ-ын Тамгын газар/
1	“Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	15	37	34	88.0%	82.5%
2	Хүний хөгжлийн бодлого	55	254	158	78.5%	69.8%
3	Эдийн засгийн бодлого	80	387	293	70.9%	62.9%
4	Засаглалын бодлого	70	272	151	76.6%	75.3%
5	Ногоон хөгжлийн бодлого	12	34	26	65.0%	63.6%
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	2	47	39	79.0%	63.9%
Нийт		234	1031	701	74.5%	69.6%

Засгийн газраас 2021 онд нийгэм, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкт хамтран Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эсрэг “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 /арван/ их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж эхэлжээ.

Засгийн газар 2021 онд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эсрэг нийгмийн халамж, хамгаалалд чиглэсэн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд илүү анхаарч ажилласан нь хөтөлбөрийн хэрэгжилттээс харагдаж байна. Тухайлбал, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 1,455.2 тэрбум төгрөг зарцуулж, нийгмийн даатгалын шимтгэлийг үе шаттай чөлөөлж аж ахуйн нэгж, датгуулагчид 150.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, айл, өрхийн цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны төлбөрт 561.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна. Мөн Монгол Улсын иргэн бүрт 300 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгожээ.

Түүнчлэн Засгийн газраас нийт иргэдийн 70 орчим хувийг Коронавируст халдварын эсрэг вакцины 1, 2, 3-р тунд хамруулж, гадаадаас 36360 иргэнээ эх оронд нь ирүүлэх ажлыг хариуцан зохион байгуулжээ.

ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

2.1.КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого"-ын хүрээнд нийт 15 зорилтын 37 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан бөгөөд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаагаар нь авч үзвэл:

- 2020 оноос хэрэгжүүлэх 27 арга хэмжээ буюу 73.0 хувь;
- 2021 оноос хэрэгжүүлэх 9 арга хэмжээ буюу 24.3 хувь;
- 2022 оноос хэрэгжүүлэх 1 арга хэмжээ буюу 2.7 хувь байна.

Засгийн газраас ирүүлсэн хэрэгжилтийн байдалд дээрх бодлогын хүрээнд 15 зорилтын 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 34 арга хэмжээ буюу 91.9 хувийн хэрэгжилтийг ирүүлж, 3 арга хэмжээ буюу 8.1 хувийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2020-2021 онд бүрэн хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 17 арга хэмжээ байна. Эдгээрээс 12 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь бүрэн хэрэгжсэн, 3 арга хэмжээний хэрэгжилт 90 хувь, 1 арга хэмжээний хэрэгжилт 50 хувь, 1 арга хэмжээний хэрэгжилт 30 хувьтай байна.

Хүснэгт 2.Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хэрэгжилт

Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого		
Зорилтын тоо		15
Арга хэмжээний тоо		37
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн арга хэмжээний тоо		34
Арга хэмжээг аргачлалын дагуу үнэлсэн байдал	100%	15
	90%	10
	70%	4
	50%	4
	30%	1
	0%	0
Хэрэгжилтийн дундаж хувь	Засгийн газар	88.0%
	УИХ-ын Тамгын газар	82.5%

(Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", Монгол Улсын Засгийн газраас УИХ-ын Тамгын газарт ирүүлсэн "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн гүйцэтгэлийн тайлан /2021 оны байдлаар/)

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого”-ын хүрээнд 2021 онд нийт 1,455.2 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд тус санхүүжилтийн ихэнх хувийг иргэд, аж ахуй нэгжид чиглэсэн нийгмийн халамж, хамгаалалд зарцуулсан нь иргэд, аж ахуйн нэгжийн эдийн засагт бодитой хувь нэмэр болсон бодлого, үйл ажиллагаа болжээ.

Хөтөлбөрийн 1.1.2.1-т тусгагдсан “цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ”, 1.1.2.4-т тусгагдсан “сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна”, 1.1.8-д тусгагдсан “гадаад улсад байгаа иргэнээ татан авах ажлыг эрчимжүүлнэ”, 1.1.11-т тусгагдсан “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцагчдад сургалтын амжилттай нь уялдуулан 100 хүртэл хувийн тэтгэлэг олгоно” зэрэг 12 арга хэмжээ “үр дүнтэй” буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 37 арга хэмжээнээс 2021 онд хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөгдсөн 2 арга хэмжээний хэрэгжилтийг тооцож ирүүлээгүй байна. Үүнд:1.1.2.8-д тусгагдсан “Олон улсын байгууллагатай хамтарсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын судалгааны ажлуудыг эхлүүлэх, үр дүнг хүлээн авна”, 1.1.7.1-т тусгагдсан “Шилжин ирэгчдийг /КОВИД-19/-ийн хариу арга хэмжээнд хамруулахад чиглэсэн судалгаа хийх, нутагтаа шилжиж ирсэн хүмүүсийн нөхцөл байдлыг үнэлэх, нийгмийн ажилтнуудад сургалт явуулах, төрийн бус байгууллагуудын үйлчилгээг дэмжих, мэдээллийн компани ажил явуулна” гэсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 15 зорилт тус бүрийг үнэлэх замаар /КОВИД-19/ халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хэрэгжилт 88.0 хувь гэж үнэлж ирүүлсэн. УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар нь тус Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын 15 зорилт, 37 арга хэмжээний хэрэгжилтийг 2021 онд хүрэх түвшинтэй харьцуулан үзэхэд тус бодлогын хэрэгжилт 82.5 хувьтай байна.

Хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлттэй харьцуулж 4 зорилтын хувийг бууруулж үнэлсэн. Тухайлбал, 1.1.6-д тусгагдсан “Нүүрс, бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилт нь “Ногоон гарц” түр журам гарсан, 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах ажил 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн зогсонги байдалд шилжсэнтэй холбоотой зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй тул хэрэгжилтийн хувийг 50 хувь болгон бууруулж үнэлсэн.

1.1.13-т тусгагдсан “Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэсэн зорилтын 2021 онд хүрэх түвшинг тогтоохдоо боловсролын багц хуульд цахим сургалтын талаарх заалтыг оруулсан байхаар төлөвлөсөн. Боловсролын ерөнхий хууль, түүнийг дагалдан гарах хуулиудад нэмэлт, өөрчлөлтийг оруулж хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн тул өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, дээд шатны байгуулагад өргөн барьсан тул хэрэгжилтийг аргачлалын дагуу 70 хувиар үнэлсэн.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г баталсан ба /КОВИД-19/ халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хэрэгжилтийг 1 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тогтоосон. Цар тахлын үеийн хүн, амын эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдэлийг бууруулах, нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах чиглэлээр шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал гэсэн энэхүү шалгуур үзүүлэлтийн суурь болон хүрэх түвшинг тогтоогоогүй нь тус шалгуур үзүүлэлтийн дагуу энэ бодлогын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй болгож байна.

2.2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд нийт 55 зорилтын 254 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан бөгөөд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаагаар нь авч үзвэл:

- 2018 оноос хэрэгжүүлж буй 1 арга хэмжээ буюу 0.4 хувь;
- 2020 оноос хэрэгжүүлж буй 122 арга хэмжээ буюу 47.1 хувь;
- 2021 оноос хэрэгжүүлэх 110 арга хэмжээ буюу 44.4 хувь;
- 2022 оноос хэрэгжүүлэх 19 арга хэмжээ буюу 7.3 хувь;
- 2023-2024 оноос хэрэгжүүлж эхлэх 2 арга хэмжээ буюу 0.8 хувь байна.

Засгийн газраас ирүүлсэн хэрэгжилтийн байдалд уг бодлогын хүрээнд 55 зорилтын 254 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 158 арга хэмжээ буюу 62.2 хувийн хэрэгжилтийг ирүүлж, 20 арга хэмжээ буюу 7.9 хувийн хугацаа болоогүй, 76 арга хэмжээ буюу 29.9 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй байна.

Хүснэгт 3. Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилт

№	Хүний хөгжлийн бодлого	Зорилтын тоо	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн арга хэмжээний тоо	Арга хэмжээг аргачлалын дагуу үнэлсэн байдал	Хэрэгжилтийн дундаж хувь /Засгийн газар/	Хэрэгжилтийн дундаж хувь /УИХ-ын Тамгын газар/
2.1	Эрүүл мэнд: Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	14	82	47	100%-9	78.5%	57.4%
					90%-7		
					70%-9		
					50%-12		
					30%-9		
0%-1							
2.2	Биеийн тамир, спорт: Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.	3	16	8	100%-1	57.7%	
					90%-2		
					70%-3		
					50%-0		
					30%-2		
0%-0							
2.3	Боловсрол: Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	16	68	40	100%-7	71.5%	
					90%-8		
					70%-9		
					50%-9		
					30%-6		
0%-1							
2.4	Шинжлэх ухаан, технологи, инновац: Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний	3	15	8	100%-3	69.5%	
					90%-0		
					70%-3		
					50%-0		
					30%-2		

	ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.				0%-0	
2.5	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал: Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.	15	47	34	100%-15 90%-6 70%-7 50%-2 30%-4 0%-0	81.8%
2.6	Үндэсний бахархал, өв соёл: Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.	4	26	21	100%-7 90%-4 70%-5 50%-3 30%-2 0%-0	80.9%
НИЙТ		55	254	158		78.5% 69.8%

(Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Засгийн газраас УИХ-ын тамгын газарт ирүүлсэн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн гүйцэтгэлийн тайлан /2021 оны байдлаар/)

“Хүний хөгжил бодлого”-ын хүрээнд цахим сургалтын нэгдсэн платформ бий болгох, цахим хичээлийн сан бүрдүүлэх зорилт тавьж улсын хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалт, үйл ажиллагааг теле хичээл, цахим хичээл хэлбэрт шилжүүлж, цахим санд 4800 цагийн теле хичээл, сурах бичгийг байршуулсан нь цар тахлын үед сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлжээ.

Мөн “Хүний хөгжил бодлого”-ын хүрээнд нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтны оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн нэгдсэн систем болох ehalamj.mn системийг нэвтрүүлж, ахмад настны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тэтгэвэр зэрэг нийт 26 төрлийн халамжийн үйлчилгээг цахим системээр олгож байгаа нь төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ач холбогдол бүхий арга хэмжээ болжээ.

Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2020-2021 онд бүрэн хэрэгжүүлэн дуусгахаар төлөвлөсөн 7 арга хэмжээ байна. Эдгээрээс 4 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь бүрэн хэрэгжсэн, 2 арга хэмжээний хэрэгжилт 90 хувь, 1 арга хэмжээний хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

“Чингис хаан” хаад язгууртны шинэ музейн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна”, “Үндэсний номын сангийн шинэ барилга угсралтын ажлыг дуусгана”, “Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II”-ын барилгын ажлыг 2021 онд дуусгана”, “Ажилтны бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалт бий болгоно” зэрэг арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн.

“Түлэнхийн төвийн барилгыг ашиглалтад оруулна”, “Үзлэгийн цаг товлох үйлчилгээг 2021 онд нэвтрүүлнэ” зэрэг ажлууд 2021 онд хүрэх зорилтот түвшиндээ хүрсэн тул үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэж 90 хувиар үнэлсэн. Харин төрөөс болон Эрүүл мэндийн даатгалаас хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг, багц, төлбөрийн хэмжээг тогтоох, зардлын тооцооллыг хийх гэсэн арга хэмжээний хэрэгжилт ирээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 254 арга хэмжээнээс 2021 онд

хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөгдсөн 76 арга хэмжээний хэрэгжилтийг тооцож ирүүлээгүй байна. Тухайлбал, 2.1.6.6-д тусгагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ”, 2.2.3.2-т тусгагдсан “Спортын төв ордон барих ажлыг эхлүүлнэ”, 2.3.3.4-т тусгагдсан “Их, дээд сургуульд элсэх шалгалтыг сургалтын хөтөлбөрт суурилан зохион байгуулж, ахлах ангийн сургалтын зарим агуулгыг их, дээд сургуулийн багц цаг /кредит/-д тооцуулах зохицуулалтыг бий болгоно”, 2.4.2.3-т тусгагдсан “Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг барина”, 2.6.2.7-д тусгагдсан “Соёлын өвийг ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн болон соёлын биет бус өвийн болон жагсаалтад бүртгүүлнэ” гэх мэт 76 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж ирүүлээгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 55 зорилт тус бүрийг үнэлэх замаар Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилт 78.5 хувь гэж үнэлж ирүүлсэн. УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар нь тус Хүний хөгжлийн бодлогын 55 зорилт, 254 арга хэмжээний хэрэгжилтийг 2021 онд хүрэх түвшинтэй харьцуулан үзэж тус бодлогын хэрэгжилт 69.8 хувьтай байна гэж үнэллээ.

Хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлттэй харьцуулж 28 зорилтын хувийг бууруулж үнэлсэн. Тухайлбал, 2.3.9-т тусгагдсан “Суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 273 цэцэрлэг, 200 шинэ сургууль ашиглалтад оруулах, тусгай хэрэгцээт сургуулийн барилгыг шинэчилж, өргөтгөх ...” зорилт нь 2021 онд хүрэх түвшиндээ хүрээгүй, хэрэгжилтийг арга хэмжээ бүрээр тайлагнаагүй тул хэрэгжилтийн хувийг бууруулж 50 хувь гэж үнэлсэн.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г баталсан ба Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг 44 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тогтоосон. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тус бодлогын 44 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшинг үнэлж ирүүлсэн. Эдгээр 44 шалгуур үзүүлэлтээс:

- 18 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшинг тодорхойлох тоон мэдээлэл гараагүй тул үнэлэх боломжгүй;
- “Үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 6 шалгуур үзүүлэлт;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 72-99 хувийн хэрэгжилттэй 14 шалгуур үзүүлэлт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 49-64 хувийн хэрэгжилттэй 5 шалгуур үзүүлэлт;
- “үр дүнгүй” буюу 0 хувийн хэрэгжилттэй 1 шалгуур үзүүлэлт тус тус байна.

100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцааг 2021 онд 21 промилль байхаар төлөвлөсөн боловч 94.9 промилль болж өссөнөөс шалтгаалан тус үзүүлэлт 0 хувь байна. 2021 онд эхийн эндэгдлийн 68 тохиолдол бүртгэгдсэний 46 нь коронавируст халдварын шалтгаант нас баралт байгаа нь эхийн эндэгдлийн харьцаа нэмэгдэх шалтгаан болсон байна. Түүнчлэн умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь, артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь суурь болон зорилтот түвшингээс буурсан нь цар тахлын үеийн хязгаарлалтаас шалтгаалж, эрт илрүүлгийн хамрагдалт буурсантай холбоотой байна.

Харин номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь, сэргээн засварласан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоо, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулсан зардал зэрэг шалгуур үзүүлэлтүүд хүрэх түвшиндээ хүрээгүй тул хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнчлэн зорилтот түвшиндээ хүрээгүй шалтгаан нөхцөлийг дурдаж ирүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн 15 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн хүрсэн түвшинг үнэлэх тоон мэдээлэл гараагүй байгаа нь уг бодлогын хэрэгжилтэд тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

2.3. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Эдийн засгийн бодлого”-ын хүрээнд нийт 7 чиглэлээр 80 зорилтын 387 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эдгээр зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаагаар нь авч үзвэл:

- 2017-2019 онд хэрэгжүүлж эхэлсэн 3 арга хэмжээ буюу 0.75 хувь;
- 2019 оноос хэрэгжүүлэх 2 арга хэмжээ буюу 0.5 хувь;
- 2020 оноос хэрэгжүүлэх 141 арга хэмжээ буюу 36.4 хувь;
- 2021 оноос хэрэгжүүлэх 180 арга хэмжээ буюу 46.5 хувь;
- 2022 оноос хэрэгжүүлэх 42 арга хэмжээ буюу 10.9 хувь;
- 2023 оноос хэрэгжүүлэх 18 арга хэмжээ буюу 4.7 хувь;
- 2024 оноос хэрэгжүүлэх 2 арга хэмжээ буюу 0.5 хувь;
- Хэрэгжиж эхлэх хугацаа тавиагүй 1 арга хэмжээ байна.

Засгийн газраас хэрэгжилтийн тайланг ирүүлэхдээ “Эдийн засгийн бодлого”-ын хүрээнд 7 чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 387 арга хэмжээнээс 293 арга хэмжээ буюу 75.7 хувийн хэрэгжилтийг ирүүлж, 38 арга хэмжээ буюу 9.8 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй, 56 арга хэмжээ буюу 14.5 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлэх хугацаа болоогүй байна.

Хүснэгт 4. Эдийн засгийн бодлого

№	“Эдийн засгийн бодлого”	Зорилтын тоо	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн арга хэмжээний тоо	Арга хэмжээг аргачлалын дагуу үнэлсэн байдал	Хэрэгжилтийн дундаж хувь /Засгийн газар/	Хэрэгжилтийн дундаж хувь /УИХ-ын Тамгын газар/
3.1	Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.	22	47	34	100%-13		
					90%-0		
					70%-8		
					50%-4		
					30%-8		
0%-1							
3.2	Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	9	66	65	100%-21	70.9%	62.9%
					90%-3		
					70%-6		
					50%-11		
					30%-15		
0%-9							
3.3	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос	15	57	57	100%-18		
					90%-9		
					70%-10		
					50%-5		

	бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.				30%-10 0%-5		
3.4	Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	9	18	18	100%-1 90%-1 70%-3 50%-5 30%-5 0%-3		
3.5	Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.	7	38	30	100%-5 90%-5 70%-7 50%-10 30%-2 0%-1		
3.6	Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.	4	100	44	100%-15 90%-3 70%-6 50%-10 30%-8 0%-2		
3.7	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	14	61	45	100%-10 90%-9 70%-10 50%-4 30%-11 0%-1		
НИЙТ		80	387	293		70.9%	62.9%

(Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Засгийн газраас УИХ-ын Тамгын газарт ирүүлсэн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2021 оны хэрэгжилт)

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 80 зорилт тус бүрийг үнэлэх замаар Эдийн засгийн бодлогын хэрэгжилт **70.9** хувь гэж үнэлж ирүүлсэн. УИХ-ын Тамгын газрын ХШҮГ нь тус Эдийн засгийн бодлогын 80 зорилт, 293 арга хэмжээний хэрэгжилтийг 2021 онд хүрэх түвшинтэй харьцуулан үзэж тус бодлогын хэрэгжилт **62.9** хувьтай байна гэж үнэллээ.

Хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлттэй харьцуулж 35 зорилтын хувийг бууруулж үнэлсэн. Тухайлбал, 3.1.1-т тусгагдсан “Инфляцын зорилтот түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, валютын нөөцийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлэх макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд инфляцын түвшинг 7 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөсөн. Хэдийгээр эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 /арван/ их наядын цогц төлөвлөгөө” зэрэг томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан хэдий ч хилийн хязгаарлалт, тээврийн зардлын өсөлт, гадаад зах зээл дээрх үнийн өсөлт зэргээс шалтгаалан инфляцын түвшин 2021 оны жилийн эцсийн байдлаар 13.4 хувьд хүрсэн тул тус зорилтын хэрэгжилтийн 70 хувийг бууруулж 50 хувиар үнэлсэн.

3.2.8-д тусгагдсан “Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна” гэсэн зорилтын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлын хангах, Евро-5 шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх, түүнчлэн Ховд аймагт хувийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй, эдгээр

арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаар тодорхой тайлагнаагүй тул тус зорилтын хэрэгжилтийн 85 хувийг бууруулж 50 хувиар үнэлсэн.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г баталсан ба Эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг 49 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тогтоосон. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тус бодлогын 49 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшинг авч үзвэл:

- 2021 онд хүрсэн түвшинг тодорхойлох тоон мэдээлэл, үзүүлэлт гараагүй тул үнэлэх боломжгүй шалгуур үзүүлэлт-2;
- "Үр дүнтэй" буюу 100 хувийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлт-23;
- "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70-99 хувийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлт-16;
- "эрчимжүүлэх шаардлагатай" буюу 31-69 хувийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлт-6; "үр дүнгүй" буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 2 шалгуур үзүүлэлт тус тус байна.

2.4.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний "Засаглалын бодлого"-ын хүрээнд нийт 70 зорилтын 272 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 116 арга хэмжээг 2020 оноос, 142 арга хэмжээг 2021 оноос, 14 арга хэмжээг 2022 оноос хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн хэрэгжилтийн тайланд тус бодлогын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 272 арга хэмжээнээс 151 арга хэмжээ буюу 55.5 хувийн хэрэгжилтийг ирүүлж, 71 арга хэмжээ буюу 26.1 хувийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна. Мөн "Зэвсэгт хүчний бүтцэд барилга-инженерийн, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний цэргийг байгуулах", "Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх" гэсэн 2 зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн 10 арга хэмжээний хэрэгжилтийг нууцын журмаар тайлагнасан байна.

Хүснэгт 5. Засаглалын бодлогын хэрэгжилт

№	"Засаглалын бодлого"	Зорилтын тоо	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн арга хэмжээний тоо	Арга хэмжээг аргачлалын дагуу үнэлсэн байдал	Хэрэгжилтийн дундаж хувь /Засгийн газар/	Хэрэгжилтийн дундаж хувь /УИХ-ын Тамгын газар/
1	"Цахим Монгол" төрийн шуурхай үйлчилгээ: Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	10	64	32	100%-15 90%-4 70%-6 50%-6 30%-1 0%-0	76.6%	81.6%
2	Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба: Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.	11	26	21	100%-6 90%-2 70%-7 50%-3 30%-2 0%-1		70.5%
3	Амар тайван, аюулгүй нийгэм: Иргэдийн аюулгүй, амар тайван, байдлыг хангана.	18	55	28	100%-4 90%-5 70%-11 50%-8		72.1%

					30%-0		
					0%-0		
4	Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл: Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.	12	31	20	100%-9	70.0%	
					90%-0		
					70%-3		
					50%-4		
					30%-3		
					0%-1		
5	Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого: Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.	10	48	33	100%-4	75.4%	
					90%-6		
					70%-21		
					50%-1		
					30%-1		
					0%-0		
6	Батлан хамгаалах: Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.	9	48	17	100%-8	82.3%	
					90%-3		
					70%-4		
					50%-1		
					30%-0		
					0%-1		
НИЙТ		70	272	151		76.6%	75.3%

(Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Засгийн газраас УИХ-ын Тамгын газарт ирүүлсэн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн гүйцэтгэлийн тайлан /2021 оны байдлаар/)

“Засаглалын бодлого”-ын хүрээнд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр шуурхай хүргэх систем e-mongolia.mn системийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хөгжүүлж, тус системээр дамжуулан 2021 оны байдлаар нийт 53 байгууллагын 562 үйлчилгээг нэгтгэж, давхардсан тоогоор нийт 5,441.581 удаагийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэд, байгууллагуудад үзүүлсэн нь тус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн нийт зорилт, арга хэмжээнээс хамгийн үр дүнтэй хэрэгжсэн зорилт, арга хэмжээ байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Засаглалын бодлогын хүрээнд 2020-2021 онд бүрэн хэрэгжүүлж дуусгахаар 13 арга хэмжээг тусгасан байна. Эдгээр арга хэмжээнээс төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй буюу бүрэн хэрэгжиж дууссан 5 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн гүйцэтгэлтэй 4, 50 хувийн хэрэгжилттэй 1, хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй 2, нууцын журмаар тайлагнасан 1 арга хэмжээ тус тус байна. Тухайлбал,

“Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлэх”, “Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх”, “Шүүх эрх мэдлийн байгууллагатай холбоотой хуулиудыг нэгтгэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төслийг батлуулах”, “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх”, “Цэргийн төв эмнэлгийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах” гэсэн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж зорилтот түвшинд хүрсэн байна.

Харин 2021 онд бүрэн хэрэгжүүлж дуусгахаар арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв байгуулах” арга хэмжээний барилгын ажлын явц 60 хувьтай, Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэн олон нийтэд ил тод, нээлттэй, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх цахим систем бий болгох ажлын явц 50 хувьтай байна. Эдгээр арга хэмжээний хэрэгжилт удааширсан шалтгаан, нөхцөлүүдийг тайлагнаж ирүүлээгүй зэрэгцээ “Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг зохион байгуулах”, “Үндэсний батлан хамгаалах их сургуулийн БХУА, номын сангийн барилгын бүтээн байгуулалтын ажлыг дуусгах, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангах арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж ирүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 272 арга хэмжээнээс 2021 онд

хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөгдсөн 71 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж ирүүлэх шаардлагатай байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, Засаглалын бодлогын 70 зорилт тус бүрийг үнэлэх замаар хэрэгжилтийг 76.6 хувиар үнэлж ирүүлсэн байна. УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар нь засаглалын бодлогын 70 зорилт, 272 арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг 2021 онд хүрэх түвшинтэй харьцуулан холбогдох аргачлалын дагуу үнэлж, тус бодлогын хэрэгжилтийг 75.3 хувиар үнэллээ.

Энэхүү үнэлгээнд хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй арга хэмжээнүүдийг оруулан тооцоолоогүй бөгөөд цөөн арга хэмжээний дундаж үзүүлэлт тул харьцангуй өндөр үнэлгээ гарсан болно.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-д Засаглалын бодлогын хэрэгжилтийг 31 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр баталсан байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тус бодлогын 31 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшинг үнэлж ирүүлснээс:

- 2021 онд хүрсэн түвшинг тодорхойлох тоон мэдээлэл, үзүүлэлт гараагүй тул үнэлэх боломжгүй шалгуур үзүүлэлт-8;
- "Үр дүнтэй" буюу 100 хувийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлт-16;
- "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70-99 хувийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлт-4;
- "эрчимжүүлэх шаардлагатай" буюу 31-69 хувийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлт-2;
- "үр дүнгүй" буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 1 шалгуур үзүүлэлт тус тус байна.

"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, сургалтанд ашигласан байдал" шалгуур үзүүлэлтийг 2021 онд 40 хувьд хүргэхээр төлөвлөсөн боловч шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт хангалтгүй буюу 20 хувьтай байгаа нь Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын хязгаарлалтаас шалтгаалан сургалтын нэгдсэн хөтөлбөр батлагдаагүйтэй холбоотой байна.

Мөн сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбох арга хэмжээний шалгуур үзүүлэлт болох "Шилэн кабелийн сүлжээнд холбох сум, суурингийн тоо" зорилтот хүрэх түвшинд хүрээгүй буюу 50 хувийн хэрэгжилттэй байгаа тул тухайн арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний зорилтот түвшин болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшингүүд хоорондоо зөрүүтэй батлагдсан байгаа нь шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг үнэлэхэд хүндрэл үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, арга хэмжээний төлөвлөгөөнд хүрэх түвшинг 2 сумыг шилэн кабелийн сүлжээнд холбохоор тусгасан байхад, хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрэх түвшинг 8 сум, сууринг шилэн кабелийн сүлжээнд холбосон байхаар баталсан нь зөрүүтэй тоон мэдээлэл байна.

"Хилийн чанадаас хуулбарлан буцаан авсан эд өлгийн зүйлс, соёлын өвийн тоо" шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй буюу 57.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа тул хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнчлэн зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан нөхцөлийг дурдаж тайлагнах шаардлагатай байна.

"Оюутан цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах их, дээд сургуулийн оюутан, МСҮТ-ийн суралцагчдын тоог шат дараатайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас хэрэгжээгүй цуцлагдсан гэж тайлагнасан боловч хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтийн тайланд зорилтот түвшиндээ бүрэн хүрч, 100 хувь хэрэгжсэнээр үнэлсэн байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлантай танилцахад арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй байхад зорилтын хэрэгжилтийг өндөр үнэлсэн байдал цөөнгүй гарч байна. Тухайлбал, Төрийн бүх шатанд авлигыг таслан зогсоох урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох зорилт тавин ажилласан байна.

Хэрэгжилт: Монгол Улс авлигын индексээр 180 орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдэж байна. АТГ 2019 онд 68, 2020 онд 114 хэрэг шалгаж, шүүхээр шийдвэрлүүлсэн. Авлигын гэмт хэргийг бий болгож байгаа суурь хүчин зүйлс буюу эрх зүйн орчныг сайжруулах, цахим шилжилтийг эрчимжүүлэхэд анхаарлаа хандуулах бөгөөд олон нийтийн дунд тандалт судалгааг 7 хоног бүр явуулж, хамтарсан төсөөллийн судалгаагаар хамгийн их хүнд суртал үүсгэж байгаа газрыг тогтоож, Авлигатай тэмцэх комисс асуудлыг шийдэхээр тогтсон гэж тайлагнасан байна.

Тухайн зорилтын хэрэгжилт хангалтгүй, 2021 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй боловч зорилтыг 90 хувь үр дүнтэй хэрэгжсэн гэж үнэлсэн нь холбогдох аргачлалын дагуу 30 хувиар үнэлэх боломжтой байна.

Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, “Оюутан цэрэг” сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Хэрэгжилтийн тайланд дурдсанаар 2 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй, оюутан цэрэг арга хэмжээ коронавируст халдварын улмаас цуцлагдсан гэж тайлагнасан боловч зорилтын хэрэгжилтийг 60 хувиар, шалгуур үзүүлэлтийг 100 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн нь тайлангийн үнэн зөв байдалд эргэлзээ төрүүлэхүйц байна.

Нэг зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өргөн цар хүрээтэй олон зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөснөөр арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй, бүрэн хэрэгжихгүй, үр дүн багатай байна. Иймээс цаашид зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тооцоо судалгаан дээр үндэслэсэн оновчтой, үр дүнтэй цөөн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, тухайн зорилтын хүрсэн түвшинг хяналт-шинжилгээ, үнэлгээний урьдчилан батлагдсан шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн дагуу гарсан үр дүнг тодорхой тайлагнах, улмаар бодитой үнэлэх шаардлагатай нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад ажиглагдаж байна.

Түүнчлэн 8 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшинг үнэлэх тоон үзүүлэлт, индекс гараагүй байгаа нь уг бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийх боломжгүй байна.

2.5. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Ногоон хөгжлийн бодлого”-ын хүрээнд нийт 12 зорилтын 34 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан бөгөөд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаагаар нь авч үзвэл:

- 2020 оноос хэрэгжүүлэх 26 арга хэмжээ буюу 76.5 хувь;
- 2021 оноос хэрэгжүүлэх 8 арга хэмжээ буюу 23.5 хувь байна.

Засгийн газраас ирүүлсэн хэрэгжилтийн байдалд уг бодлогын хүрээнд 12 зорилтын 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 26 арга хэмжээ буюу 76.5 хувийн хэрэгжилтийг ирүүлж, 8 арга хэмжээ буюу 23.5 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй байна.

Хүснэгт 6. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.		
Зорилтын тоо		12
Арга хэмжээний тоо		34
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн арга хэмжээний тоо		26
Арга хэмжээг аргачлалын дагуу үнэлсэн байдал	100%	3
	90%	3
	70%	7
	50%	7
	30%	5
	0%	1
Хэрэгжилтийн дундаж хувь	Засгийн газар	65.0%
	УИХ-ын Тамгын газар	63.6%

(Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Засгийн газраас УИХ-ын Тамгын газарт ирүүлсэн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн гүйцэтгэлийн тайлан /2021 оны байдлаар/)

Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 2020 болон 2021 онуудад хэрэгжүүлж дуусгахаар тусгасан арга хэмжээ байхгүй бөгөөд 2021-2024 оны хооронд үргэлжлэн хэрэгжихээр байна.

5.1.2-т тусгагдсан “Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Ерөнхий сайдын 2020 оны 117 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, нуурын ёроолд живсэн 50 м хүртлэх гүнээс тээврийн хэрэгслийг татаж гаргах ажил 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлж, нуурт 1985 онд живсэн Сүхбаатар хөлөг онгоцыг татаж гаргасан байна. Энэхүү зорилт нь “орчин үеийн техник хэрэгсэл ашиглан нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлын даалгавар боловсруулсан байна” гэсэн зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн тул хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлсэн.

5.1.4.3-т тусгагдсан “ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тогтвортой менежментийг хангах стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ”, 5.1.6.2-т тусгагдсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын дэд бүтэц, материаллаг баазыг сайжруулна”, 5.1.7.3-т тусгагдсан “Генетик нөөцийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэнэ” гэсэн арга хэмжээнүүд 2021 онд хүрэхээр төлөвлөсөн зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 34 арга хэмжээнээс 2021 онд хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөгдсөн 5 арга хэмжээний хэрэгжилтийг тооцож ирүүлээгүй байна. Эдгээрт 5.1.1.2-д тусгагдсан “Томоохон хот, суурин газруудад агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлнэ”, 5.1.5.4-т тусгагдсан “Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ”, 5.1.12.2-т тусгагдсан “Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана”, 5.1.12.4-т тусгагдсан “Ус, цаг агаарын урьдчилан сэргийлэх дунд, урт хугацааны мэдээ боловсруулах суперкомпьютерийг шинэчилнэ”, 5.1.12.7-д тусгагдсан “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох, цахим системийг нэвтрүүлнэ” зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж ирүүлээгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 12 зорилт тус бүрийг үнэлэх замаар Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт 65.0 хувь гэж үнэлж ирүүлсэн. УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар нь тус Ногоон хөгжлийн бодлогын 12

зорилт, 34 арга хэмжээний хэрэгжилтийг 2021 онд хүрэх түвшинтэй харьцуулан үзэж тус бодлогын хэрэгжилт 63.6 хувьтай байна гэж үнэллээ.

Хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлттэй харьцуулж 5 зорилтын хувийг бууруулж үнэлсэн. Тухайлбал, 5.1.1-т тусгагдсан “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ” гэсэн зорилтын “Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх” гэсэн арга хэмжээ нь ус, дулаан, цахилгаан холбоо, дохиоллын шугам сүлжээний зураг төслийг боловсруулах гэсэн 2021 онд хүрэх зорилтот түвшиндээ хүрээгүй тул хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувиар үнэлсэн.

5.1.3-т тусгагдсан “Усны нөөцийг бохирдол, хомсдлоос сэргийлэх, нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, нийслэлийн цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана”, 5.1.4-т тусгагдсан “Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко” жорлон арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна” зэрэг арга хэмжээнүүд 2021 онд хүрэх түвшиндээ хүрээгүй, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байхаас гадна 2021 оны хэрэгжилтийг шинэчлэн ирүүлэлгүй 2020 оны хэрэгжилтийн тайланд ирүүлсэн мэдээг дахин ирүүлсэн байна.

Мөн 5.1.9 дүгээр зорилтын 1 дэх арга хэмжээ болох “Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулна” гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг “...төвлөрсөн байгууламж барих зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршлыг тогтоох тооцоо, судалгааг нарийвчлан хийж байна.” гэж тайлагнасан тул бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа гэж үзэж хэрэгжилтийг аргачлалын дагуу 0 хувь болгон бууруулж үнэллээ.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г баталсан ба Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг 14 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тогтоосон. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тус бодлогын 14 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшинг үнэлж ирүүлсэн. Эдгээр 14 шалгуур үзүүлэлтээс:

- 4 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшинг тодорхойлох тоон мэдээлэл гараагүй тул үнэлэх боломжгүй;
- “Үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 7 шалгуур үзүүлэлт;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 95.5 хувийн хэрэгжилттэй 1 шалгуур үзүүлэлт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 56.3 хувийн хэрэгжилттэй 1 шалгуур үзүүлэлт;
- “үр дүнгүй” буюу 0 хувийн хэрэгжилттэй 1 шалгуур үзүүлэлт тус тус байна.

Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувийг 2021 онд 15 хувьд хүргэхээр төлөвлөсөн боловч хөрөнгө оруулалт шийдэгдээгүй тул энэ ажил хийгдээгүй тул тус шалгуур үзүүлэлт хангагдаагүй 0 хувийн биелэлттэй байна.

Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI 57.2 оноо байхаар төлөвлөсөн хэдий ч 2021 онд 32.2 оноо байгаа нь тус шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 56.3 хувь байхад нөлөөлж байна.

Түүнчлэн 4 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн хүрсэн түвшинг үнэлэх тоон мэдээлэл гараагүй байгаа нь уг бодлогын хэрэгжилтэд тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

2.6. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

Үйл ажиллагааны хөтөлбөрийн “Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ын хүрээнд 27 зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаснаас 2020 оноос хэрэгжүүлэх 10 арга хэмжээ, 2021 оноос хэрэгжүүлэх 34 арга хэмжээ, 2022 оноос хэрэгжүүлэх 2 арга хэмжээ, 2023 оноос хэрэгжүүлэх 1 арга хэмжээ тус тус байна.

Тус бодлогын хүрээнд хэрэгжүүлэх нийт 42 арга хэмжээний хэрэгжилтийг ирүүлэхээс 40 арга хэмжээ буюу 95.2 хувийн хэрэгжилтийг гарган ирүүлсэн нь өнгөрсөн онд ирүүлсэн байдалтай харьцуулахад сайшаалтай үзүүлэлт байна. “Улаанбаатар хотын гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах ажлын хүрээнд гэр хорооллын газрын дахин төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж, төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх”, “Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийг өргөх машин механизм, цахилгаан утасны лаборатори, барилгын физикийн лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах” арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж ирүүлээгүй байна.

“Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-д тусгагдсан зорилтын хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт

Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого		6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгох чиглэлээр	6.2.Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр
Зорилтын тоо		1	1
Арга хэмжээний тоо		29	18
Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй арга хэмжээний тоо		1	1
Хэрэгжүүлэх хугацаа болоогүй арга хэмжээ		5	1
Арга хэмжээг аргачлалын дагуу үнэлсэн байдал	100%	10	3
	90%	1	1
	70%	4	3
	50%	4	2
	30%	2	7
	0%	2	0
Хэрэгжилтийн дундаж хувь	Засгийн газар	79%	
	УИХ-ын Тамгын газар	63.9%	

(Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Засгийн газраас УИХ-ын Тамгын газарт ирүүлсэн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн гүйцэтгэлийн тайлан /2021 оны байдлаар/)

“Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ын хүрээнд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг тус тус баталсан. Эдгээр хуулиуд батлагдсанаар өмчийн захиран зарцуулах эрхийг сум, дүүрэгт шилжүүлж, төсвийн төвлөрсөн байдлыг багасгах арга хэмжээг авсан нь төвлөрлийг сааруулах болон бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг бий болгожээ.

“Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ын хүрээнд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн зүүн бүсэд жилд 600 мянган

тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг байгуулан ашиглалтад оруулж, “Таван толгой түлш” ХХК-ийн баруун болон зүүн бүсийн үйлдвэр нь 666,815 тонн сайжруулсан түлшийг 686 борлуулалтын цэг, 28 хангамж, 35 нөөцийн агуулахад тээвэрлэн 198,000 айл өрхийг сайжруулсан түлшээр хангаж байгаа нь зорилтот түвшинг бүрэн хангахын зэрэгцээ, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн томоохон арга хэмжээ болсон.

“Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 42 арга хэмжээнээс 90-100 хувийн хэрэгжилттэй 15 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ, 50 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, 0-30 хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ байна.

2020-2021 онд бүрэн хэрэгжүүлж дуусгахаар 2 арга хэмжээг төлөвлөснөөс 1 арга хэмжээ 100 хувь буюу бүрэн хэрэгжиж, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах арга хэмжээний хэрэгжилт 70 хувийн хэрэгжилттэй байна. Бусад арга хэмжээнүүдийг 2021-2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, “Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ын 27 зорилт тус бүрийг үнэлэх замаар хэрэгжилт 79 хувь гэж үнэлсэн байна. УИХ-ын Тамгын газрын ХШҮГ нь тус бодлогын 27 зорилт, 47 арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг 2021 онд хүрэх түвшинтэй харьцуулан аргачлалын дагуу үнэлж, тус бодлогын хэрэгжилтийг 63.9 хувьтай хэрэгжсэн гэж үнэллээ.

“Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-гээр Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг 13 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр баталсан байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд уг бодлогын 13 шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшинг үнэлж ирүүлснээс:

- 2021 онд хүрсэн түвшинг тодорхойлох тоон мэдээлэл гараагүй тул үнэлэх боломжгүй шалгуур үзүүлэлт 1;
- “Үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлт 9;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй шалгуур үзүүлэлт 1;
- “үр дүнгүй” буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 2 шалгуур үзүүлэлт тус тус байна.

Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд “Цахилгаан соронзон тээврийн төслийг хэрэгжүүлж эхлэх”, “Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк”-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулах” гэсэн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч санхүү, хөрөнгө оруулалтын асуудлаас шалтгаалан хэрэгжээгүй байна.

Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 2475 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээнд холбохоор төлөвлөсөн боловч хөл хорио тогтоосонтой холбоотойгоор бүтээн байгуулалтын ажил зогссоны улмаас 8.1 хувийн хэрэгжилттэй байна. Тус арга хэмжээний хүрээнд Налайх дүүрэгт 201 өрхийг гадна инженерийн шугам сүлжээнд холбосон байна.

Нийтийн тээврийн үйлчилгээнд зорчигчдыг ая тухтай зорчих нөхцөлийг хангасан ухаалаг, эко, цахилгаан хөдөлгүүрт дан болон давхар автобус, цахилгаан соронзон болон дүүжин замын тээврийн хэрэгслийг хэрэглээнд үе шаттайгаар нэвтрүүлэх зорилт тавьж, 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тайланд дурдсанаар “цахилгаан соронзон тээврийн төсөл” төсөв санхүүжилтгүйгээс эхлээгүй, “Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль

орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглолтой 80 тээврийн хэрэгслийг шинээр авахаар төлөвлөсөн ч хэрэгжилт 12.5 хувьтай, дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн нэгдүгээр шатны ажлын бэлтгэл хангагдаж, зорилтын хэрэгжилт 29 хувьтай байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй, үр дүнтэй хэрэгжээгүй байхад тухайн зорилтын хэрэгжилтийг өндөр үнэлсэн байдал цөөнгүй гарч байна. Тухайлбал, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих “Сургуулийн автобус” төслийг үргэлжүүлэх зорилтод чиглэсэн стандартын шаардлага хангасан тусгай зориулалт бүхий 75 автобус (нийт 23 тэрбум төгрөг) хүлээн авахаар гэрээ байгуулж эхний ээлжийн 5 автобусыг хүлээн авсан гэж 2021 оны 03 дугаар сард УИХ-д ирүүлж байсан хэрэгжилтийн тайлан мэдээнд өөрчлөлт ороогүй байгаа нь тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ахиц гараагүй байна. Мөн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих замаар сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах, сум орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх зорилт зэрэг болно.

Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилт удаашралтай, хангалтгүй байгаа шалтгаан, нөхцөлийг тодруулан тайлагнаагүй байгааг анхаарч, улмаар хэрэгжилтийг эрчимжүүлж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ

1. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 6 бодлогын хүрээнд дэвшүүлсэн нийт 234 зорилт, 1031 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2021 оны байдлаар 701 арга хэмжээ буюу **68.0 хувийн хэрэгжилтийг ирүүлж**, 194 арга хэмжээ буюу 18.8 хувийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна. Харин 136 арга хэмжээ буюу 13.2 хувийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.
2. Засгийн газраас “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2021 оны хэрэгжилтийг **74.5** хувьтай гэж үнэлж ирүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын Тамгын газраас уг хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу үнэлэхэд **69.6** хувьтай байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг бодлого тус бүрээр харуулбал:

№	Бодлогууд	Хэрэгжилтийн дундаж хувь	
		Засгийн газар	УИХ-ын Тамгын Газар
1	“Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	88.0%	82.5%
2	Хүний хөгжлийн бодлого	78.5%	69.8%

3	Эдийн засгийн бодлого	70.9%	62.9%
4	Засаглалын бодлого	76.6%	75.3%
5	Ногоон хөгжлийн бодлого	65.0%	63.6%
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	79.0%	63.9%
Нийт		74.5%	69.6%

3. Улсын Их Хурлын Тамгын газраас хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг зорилт, арга хэмжээ тус бүрээр үнэлэхэд:
- Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн 202 арга хэмжээ буюу 28.8 хувь;
 - Зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхлэж байгаа, цаашид үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 248 арга хэмжээ буюу 35.4 хувь;
 - Зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтот чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай 115 арга хэмжээ буюу 16.4 хувь;
 - Зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй 136 арга хэмжээ буюу 19.4 хувь байна.
4. Улсын Их Хурлын Тамгын газраас хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газраас ирүүлсэн дараах **105 зорилтын** хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн хувийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу үнэлгээний хувийг бууруулан үнэлсэн болно. Үүнд:
- “Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд 4 зорилт;
 - Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 28 зорилт;
 - Эдийн засгийн бодлогын хүрээнд 35 зорилт;
 - Засаглалын бодлогын хүрээнд 24 зорилт;
 - Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 5 зорилт;
 - Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 9 зорилт буюу нийт 105 зорилт болно.
5. “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан бөгөөд энэхүү төлөвлөгөөнд 2021 оноос хэрэгжүүлэхээр заасан 21 арга хэмжээ санхүү, хөрөнгө оруулалтаас шалтгаалан хэрэгжиж эхлээгүй байна.
6. Засгийн газраас хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийн тайланг ирүүлэхдээ зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт нь 2020 онд ирүүлсэн хэрэгжилтийг давтан ирүүлэх, 2021 онд хийгдсэн нэмэлт ажлын талаар тайлагнахгүйгээр хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлж ирүүлэх, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тайлагнахгүй байх, зорилт, арга хэмжээний хүрсэн үр дүнг тодорхой бус, ерөнхий байдлаар хэрэгжилтийн явцыг тоочих байдлаар нэгтгэн ирүүлсэн байна.

7. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн бөгөөд хүрсэн түвшинг үнэлэх тоон үзүүлэлт, индекс гараагүй байгаа нь бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нөхцөлийг хязгаарлаж байна.
8. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас хөтөлбөрийн зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрэхгүй байх, улмаар тухайн бодлогын хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан нөхцөл болсон байна. Тухайлбал,
- Арга хэмжээ 2.1.9.7-т тусгагдсан “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ” гэсэн арга хэмжээ цар тахлын улмаас гадаад сургалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тулгарсан хэдий ч олон улсын мэргэжлийн чиглэлийн нийгэмлэг, холбоодын нэр хүнд бүхий алсын зүйн, цахим төлбөртэй сургалтуудад эмч, мэргэжилтнүүдээ хамруулахыг зорьж давхардсан тоогоор 349 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан.
 - Арга хэмжээ 2.3.2.1-т тусгагдсан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах насыг 3-5 нас, СӨБ-ын хамран сургалтыг 87.3 хувьд хүргэхээр төлөвлөсөн хэдий ч цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор 79.7 хувь болж өмнөх оноос 4.5 хувиар буурсан байна.
9. Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тухайн онд хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын утгын дагуу Засгийн газраас хэрэгжилтийг тайлагнахгүй байгаа нь зорилт, арга хэмжээний явцыг үнэлэхэд хүндрэл учруулж байна.
10. Нэг зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өргөн цар хүрээний олон арга хэмжээнүүдийг төлөвлөснөөр арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, бүрэн хэрэгжихгүй үр дүн багатай байна. Иймээс цаашид зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн оновтой, үр дүнтэй цөөн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, тухайн зорилтын хүрсэн түвшинг хяналт-шинжилгээ, үнэлгээний урьдчилан батлагдсан шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн дагуу гарсан үр дүнг тодорхой тайлагнах, улмаар бодитой үнэлэх шаардлагатай нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад ажиглагдаж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

---oOo---